МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 21 өдөр Дугаар А/86 Мөрөн сум

Хайгуулын тусгай зөвшөөрөл
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.7, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 14 дүгээр зүйлийн 14.7, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох (1) аж ахуйн нэгжийн нэр, талбайн хэмжээ, байршил, солбицол, тусгай зөвшөөрлийн хугацааг хавсралт ёсоор баталсугай.

2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр), аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал), Бүрэнтогтох сумын Засаг дарга (А.Аззаяа) нарт тус тус даалгасугай.

3.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбайг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т даалгасугай.

4.Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг аймаг орон нутгийн орлогод төвлөрүүлж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-т үүрэг болгосугай.

5.Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022
оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/ 26
дугаар захирамжийн хавсралт

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТАЛБАЙ, СОЛБИЦОЛ, ХУГАЦАА

№	Аж ахуйн нэгжийн нэр	Сум, талбайн нэр	Талбайн хэмжээ га	Хугацаа		Солбицол	
				Эхлэх	Дуусах	Уртраг	Өргөрөг
1	Бат дөрвөн бэрх ХХК	Бүрэнтогтох сум Гонгоон гарам	28,2	2022 оны 03 сарын 21	2025 оны 03 сарын 21	100 01 19.03 100 01 19.19 100 00 52.54 100 00 52 54	49 38 1.19 49 38 18.45 49 38 18.2 49 38 1.19

o0o